



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 23 өдөр

Дугаар 5/20

Жавхлант

Х.Энх-Уянгыг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 38 дугаар зүйлийн 38.6, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6, Улсын Их Хурлын 2007 оны 73 дугаар тогтоолын (улс төрийн албан тушаалын албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай) 1 дэх заалт, Засгийн газрын 2024 оны “төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох тухай” 82 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хувийн ашиг сонирхлын урьдчилан мэдүүлгээ Авлигатай тэмцэх газарт хянуулж, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй Хэрлэнбаатарын Энх-Уянгыг Дэлгэрхаан багийн Засаг даргаар томилсугай.


2. Ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Т.Эрдэнэцэцэг	Санхүүгийн албаны дарга
Гишүүдэд:	С.Наранцэцэг	Нягтлан бодогч
	Г.Батсайхан	Нярав

3. Х.Энх-Уянгын үндсэн цалинг 1 458 000 (нэг сая дөрвөн зуун тавин найман мянга) төгрөгөөр, Улс төрийн албан тушаалын албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг албан тушаалын цалингийн 30 хувиар, орон нутгийн нэмэгдлийг 60 хувиар тус тус тооцож олгохыг Нягтлан бодогч (Э.Уранбайгаль)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2025 оны 03 дугаар сарын 14-ны өдрийн Б/07 тоот захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.БАТЧУЛУУН